



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24дүгээр зүйлийн 2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын 2011 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоорон нутгийн биеийн тамир, спортын байгууллагын биеийн тамир, спортын хөгжлийн явц, үйл ажиллагааны үр дүнг тайлагнах зааврыг хавсралтаар баталсугай.

2. Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газрын дарга нарт үүрэг болгох нь:

а/ орон нутгийн биеийн тамир, спортын хөгжлийн хөтөлбөр боловсруулж батлуулах;

б/ орон нутгийн байгууллагаас биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаарх бодлого, үйл ажиллагааны үр дүнг тайлагнах;

в/ зааврын дагуу тайланг боловсруулан тухайн оны 2 дугаар сарын 1-ний дотор багтаан Эрүүл мэнд, спортын яамны харьяа Биеийн тамир, спортын хөгжлийн төвд ирүүлж байх.

3. Аймаг, орон нутгийн тайланг нэгтгэн жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор багтаан Эрүүл мэнд, спортын яаманд ирүүлж байхыг Биеийн тамир, спортын хөгжлийн төв /П.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

4. Орон нутгийн биеийн тамир, спортын байгууллагын чадавхийг бэхжүүлэх, тайлагнах тогтолцоог бүрдүүлэхэд зөвлөмжөөр хангаж ажиллахыг Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Х.Бакытжан/-т үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Ламбаа/-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

D:\barimt\tushaal

080021

Эрүүл мэнд, спортын сайдын  
2016 оны 4 сарын 2 өдрийн  
6 дугаар тушаалын хавсралт

**ОРОН НУТГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГЫН БИЕИЙН  
ТАМИР, СПОРТЫН ХӨГЖЛИЙН ЯВЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ  
ТАЙЛАГНАХ ЗААВАР**

**Нэг. Нийтлэг зүйл**

1.1.Орон нутгийн биеийн тамир, спортын байгууллагын биеийн тамир, спортын хөгжлийн явц, бодлого, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, үнэн, зөв мэдээлэлд суурилсан бодлогын хувилбар боловсруулах, зөвлөмж, чиглэлээр хангахад энэхүү зааврын зорилго оршино.

1.2.Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын байгууллагууд орон нутаг дах биеийн тамир, спортын бодлого, үйл ажиллагаа, үр дүн, тайлагнахдаа энэхүү зааврыг мөрдлөг болгоно.

**Хоёр. Тайлан ирүүлэх, нэгтгэх, олон нийтэд мэдээлэх**

2.1.Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газар энэхүү журмын дагуу “Орон нутгийн биеийн тамир, спортын хөгжил” тайланг боловсруулна.

2.2. Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газар нь өмнөх жилийн тайланг тухайн оны 2 дугаар сарын 01-ний дотор багтаан Эрүүл мэнд, спортын яамны харьяа Биеийн тамир, спортын хөгжлийн төвд жил бүр ирүүлнэ.

2.3.Дүүргийн биеийн тамир, спортын хороод 1 дугаар сарын 15-ний дотор багтаан нийслэлийн биеийн тамир, спортын газарт тайланг ирүүлнэ.

2.4. Аймаг, нийслэлийн “Орон нутгийн биеийн тамир, спортын хөгжил”-ийн тайланг Эрүүл мэнд, спортын яамны харьяа Биеийн тамир, спортын хөгжлийн төв нэгтгэж, 3 дүгээр сарын 1-ний дотор улсын хэмжээний тайланг ЭМСЯ болон олон нийтэд мэдээлнэ.

2.5. Тайланг кирилл үсгийн “Arial” 12 хэмжээтэй Word программ ашиглан боловсруулж, байгууллагын дарга, ахлах мэргэжилтэн, нягтлан бодогчийн гарын үсэг, байгууллагын тамгаар баталгаажуулж ирүүлнэ. Мөн тайланг Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн холбогдох мэргэжилтэнд цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.6. Тайлан нь орон нутгийн биеийн тамир, спортын байгууллагын удирдах ажилтны ажлын үр дүнг үнэлэх үндэслэл болно.

44

2.7. Тайлагналт, удирдах ажилтны ажлын үр дүнг ЭМСЯ-наас аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүр мэдээлнэ.

### **Гурав. Тайлан боловсруулахарга зүй**

3.1. Тайланг боловсруулахдаа Үндэсний статистикийн газрын даргын зөвшөөрснөөр Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2007 оны 362 дугаар тушаалаар батлагдсан "Захиргааны статистик мэдээлэл"-ийн тухайн оны үзүүлэлтэд үндэслэнэ.

3.2. Тус зааврын хавсралтад тусгасан үзүүлэлтийг тухайн оны албан ёсны статистик мэдээлэл, бусад судалгаа, дүгнэлтийг ашиглан тайлагнана.

3.3. Шалгуур үзүүлэлтийг тооцохдоо албан ёсны статистик мэдээллийн тоон үзүүлэлтийг тус зааврын хавсралтад заасан аргачлалын дагуу томьёоллоор бодож гаргана.

3.4. Шалгуур үзүүлэлт бүрээр индексг гаргаж, индекс хоорондын хамаарал, өмнөх онтой харьцуулан өсөлт, бууралтын учир шалтгаан, дүгнэлтийг тусгаж тайланг боловсруулна.

3.5. Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газар нь 2016 оны "Орон нутгийн биеийн тамир, спортын хөгжил"-ийн тайланг суурь болгон дараа оны тайланг боловсруулах ба өсөлт, бууралтыг харьцуулж дүгнэлт гаргана.

3.6. Орон нутгийн тайланг аймгийн хэмжээнд аймгийн биеийн тамир, спортын газар, нийслэлийн хэмжээнд нийслэлийн биеийн тамир, спортын газар боловсруулах бөгөөд орон нутаг дах биеийн тамир, спортын бодлого, үйл ажиллагаа, үр дүн, тулгамдсан асуудал, дүгнэлт, цаашид анхаарах асуудлыг судалгаа, статистик мэдээлэлд тулгарлын тайлагнана.

25

Орон нутгийн биеийн тамир,  
спортын байгууллагын биеийн  
тамир, спортын хөгжлийн явц,  
үйл ажиллагааны үр дүнг  
тайлагнах зааварын хавсралт

**ОРОН НУТГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГЫН БИЕИЙН  
ТАМИР, СПОРТЫН ХӨГЖЛИЙН ЯВЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ  
ТАЙЛАГНАХ ҮЗҮҮЛЭЛТ**

№	Үзүүлэлт	Дүгнэх аргачлал	Тоон утга	Тоон үзүүлэлт
<b>Нэг. Гүйцэтгэлийн индекс</b>				
1	Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөр дахь БТС-ын зорилтын хэрэгжилтийн индекс	Г <sub>1</sub> - Гүйцэтгэл буюу хүрсэн төвшин	$\frac{ЗГХИ}{Г1/Т1}$	
		Т <sub>1</sub> - Төлөвлөсөн буюу хүрэх төвшин		
2	Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн индекс	Г <sub>2</sub> - Гүйцэтгэл буюу хүрсэн төвшин	$\frac{ОНХИ}{Г2/Т2}$	
		Т <sub>2</sub> - Төлөвлөсөн буюу хүрэх төвшин		
3	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн индекс	Г <sub>3</sub> - Гүйцэтгэл буюу хүрсэн төвшин	$\frac{ҮХИ}{Г3/Т3}$	
		Т <sub>3</sub> - Төлөвлөсөн буюу хүрэх төвшин		
4	БТС-ны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийн индекс	Г <sub>4</sub> - Гүйцэтгэл буюу хүрсэн төвшин	$\frac{ТИ}{Г4/Т4}$	
		Т <sub>4</sub> - Төлөвлөсөн буюу хүрэх төвшин		
<b>Хоёр. Санхүүгийн үйл ажиллагааны үзүүлэлт</b>				
5	Нэг хүнд ноогдох БТС-ын арга хэмжээний санхүүжилтын индекс	Т <sub>ax</sub> - Орон нутгийн Биеийн тамир, спортын арга хэмжээний төсөв	$\frac{АХСИ}{Тax/Нx}$	
		Н <sub>x</sub> - Орон нутгийн нийт хүн амын тоо		
6	Нэг хүнд ноогдох БТС-ын нийт санхүүжилтын индекс	Н <sub>t</sub> - Орон нутгийн Биеийн тамир, спортын нийт санхүүжилт	$\frac{НТСИ}{Нt/Нx}$	
		Н <sub>x</sub> - Орон нутгийн нийт хүн амын тоо		
7	Ивээн тэтгэгчдийн санхүүжилтын индекс	ИТ <sub>c</sub> - Ивээн тэтгэгчдийн санхүүжилтын нийт хэмжээ	$\frac{ИТСИ}{ИТc/Тax}$	
		Т <sub>ax</sub> - Орон нутгийн		

		Биеийн тамир, спортын арга хэмжээний төсөв			
<b>Гурав. Хүний нөөцийн үзүүлэлт</b>					
8	Хүний нөөцийн индекс	Н <sub>х</sub> - Орон нутгийн нийт хүн амын тоо М <sub>а</sub> -Биеийн тамир, спортын мэргэжилтэй ажилтаны тоо	$XHI = N_x / M_a$		
9	Дасгалжуулагчдын индекс	СХ <sub>т</sub> -Спортоор хичээллэгчдийн тоо Д <sub>т</sub> – Дасгалжуулагчдын нийт тоо	$DI = CX_t / D_t$		
10	Арга зүйчдийн индекс	Н <sub>х</sub> - Орон нутгийн нийт хүн амын тоо АЗ <sub>т</sub> –Арга зүйчдийн нийт тоо	$AZI = N_x / AZ_t$		
<b>Дөрөв. Спортын барилга байгууламжийн хүртээмж, ашиглалтын индекс</b>					
11	Спортын барилга байгууламжийн хүртээмжийн индекс	СББ <sub>тх</sub> – Спортын барилга байгууламжийн нийт талбайн хэмжээ /м.кв/ Н <sub>х</sub> - Орон нутгийн нийт хүн амын тоо	$СББИ = СББ_{тх} / N_x$		
12	Спортын барилга байгууламжийн ашиглалтын индекс	Ац- Спортын барилга байгууламжийг ашигласан нийт цаг Н <sub>ц</sub> – Жилийн турш ажиллах нийт цаг	$AI1 = A_c / N_c$		
13	Спортын барилга байгууламжийн ашиглалтын индекс	ТҮц- Спортын барилга байгууламжийн төлбөртэй үйлчилгээ үзүүлсэн нийт цаг Н <sub>ц</sub> – Жилийн турш ажиллах нийт цаг	$AI2 = T_y_c / N_c$		
14	Спортын барилга байгууламжийн ашиглалтын индекс	Сц- Спортын барилга байгууламжийг биеийн тамир, спортын зориулалтаар ашигласан нийт цаг Н <sub>ц</sub> – Жилийн турш ажиллах нийт цаг	$AI3 = C_c / N_c$		
15	Спортын барилга байгууламжийн ашиглалтын индекс	Бц- Спортын барилга байгууламжийг бусад зориулалтаар ашигласан нийт цаг	$AI4 = B_c / N_c$		

		$H_{ц}$ – Жилийн турш ажиллах нийт цаг			
<b>Тав. Биеийн тамирын үзүүлэлт</b>					
16	Өсвөр үеийнхний бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшний индекс	$X_{Тх}$ – Хангалттай түвшинг хангасан хүүхдийн тоо $H_x$ – Нийт хүүхдийн тоо	$\Theta Y_{и} = X_{Тх}/H_x$		
17	Залуучуудын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшний индекс	$X_{Тз}$ – Хангалттай түвшинг хангасан залуучуудын тоо $H_з$ – Нийт залуучуудын тоо	$Z_{и} = X_{Тз}/H_з$		
18	Насанд хүрэгчдийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшний индекс	$X_{Тнд}$ – Хангалттай түвшинг хангасан насанд хүрэгчдийн тоо $H_{нх}$ – Нийт насанд хүрэгчдийн тоо	$H_{Хи} = X_{Тнх}/H_{нх}$		
19	Ахмадуудын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшний индекс	$X_{Та}$ – Зохиох түвшинг хангасан ахмадын тоо $H_a$ – Нийт ахмадын тоо	$A_{и} = X_{Та}/H_a$		
20	Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдагсдын индекс	$C_{Ат}$ – Сорил авсан нийт хүн амын тоо $H_x$ – Орон нутгийн нийт хүн амын тоо	$C_{Хи} = C_{Ат}/H_x$		
21	Өсвөр үеийнхний хөдөлгөөний хомсдолтой индекс	$XX_{өү}$ – өдөрт 60-аас доош минут идэвхтэй дасгал хөдөлгөөн хийдэг $H_x$ – Нийт хүүхдийн тоо	$XX_{и} = XX_{өү}/H_x$		
22	18 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлгөөний хомсдлын индекс	$XX_{нх}$ – долоо хоногт 150-иас доош минут идэвхтэй дасгал хөдөлгөөн хийдэг хүн амын тоо $H_{нх}$ – Нийт насанд хүрэгчдийн тоо	$XX_{и} = XX_{нх}/H_x$		
<b>Зургаа. Спортын үзүүлэлт</b>					
23	Спортоор хичээллэгч өсвөр үеийнхний индекс	$C_{Хө}$ – Спортоор хичээллэгч өсвөр үеийнхний тоо $H_x$ – Нийт хүүхдийн тоо	$\Theta Y_{Си} = C_{Хө}/H_x$		
24	Спортоор хичээллэгч залуучуудын индекс	$C_{Хз}$ – Спортоор хичээллэгч залуучуудын тоо $H_з$ – Нийт залуучуудын тоо	$Z_{Си} = C_{Хз}/H_з$		

25	Спортоор хичээллэгч насанд хүрэгчдийн индекс	СХ <sub>н</sub> – Спортоор хичээллэгч насанд хүрэгчдийн тоо	$\frac{НХ_{Си}}{=СХ_{нх}/Н_{нх}}$		
		Н <sub>нх</sub> – Нийт насанд хүрэгчдийн тоо			
24	Улсын аварга шалгаруулах тэмцээний амжилтын индекс	А <sub>м</sub> – Улсын аварга шалгаруулах тэмцээнээс авсан медалийн тоо	$M_{и} = A_{м}/H_{м}$		
		Н <sub>м</sub> – Нийт медалийн тоо			
25	Спортоор хичээллэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн индекс	СХ <sub>хби</sub> – Спортоор хичээллэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	$\frac{ХБ_{Си}}{=СХ_{хби}/Н_{хби}}$		
		Н <sub>хби</sub> – Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо			

ᠶᠭ